

**Монгол Улс**  
**НЭЗХДШ болон ТС-ийг боловсруулах хүрээнд Хэнтий аймгийн**  
**орон нутгийн удирдлагуудтай хийсэн зөвлөлдөх уулзалт**  
**2017 оны 10-р сарын 5**

*Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл [ibaatarkhuu@worldbank.org](mailto:ibaatarkhuu@worldbank.org) и-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.*

Дэлхийн Банк Групп (ДБГ) нь Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодол сонсох, солилцох зорилгоор 2017 оны 10 дугаар сарын 5-нд Хэнтий аймгийн засаг захиргаа, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч бүхий 21 хүнтэй уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

- 1) Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
- 2) Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
- 3) Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

<b>Ангилал</b>	<b>Оролцогчдын санал</b>
----------------	--------------------------

**Улс орны хөгжлийн дүн шинжилгээ (ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга зам, боломж, сорилт, бэрхшээл)**

**Боломж:**

- Байгалийн нөөцөөс орж ирж буй орлогыг зөв зохистой ашиглавал эдийн засгийн хөгжлийн олон боломжууд байна.
- Монголд мэдлэгт суурилсан эдийн засгийг байгуулах боломж байна. Ирээдүйд аж үйлдвэрлэлд суурилсан эдийн засгийн хөгжил рүү шилжих нь мөн өөр нэг хөгжлийн боломж болно. Засгийн газрын шинжлэх ухаан, технологи, инновацид чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг агентлаг үүнд дэмжлэг үзүүлэх боломжтой.
- Хэнтий аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх маш их потенциал байна.
- Дотоодын зах зээл, бүх нийтэд бэлэн мөнгө олгосон нь сүүлийн жилүүдэд өсөлтөд нөлөөлөх хүчин зүйл болсон.
- Зах зээлийн эдийн засагт шилжин, ардчиллыг бэхжүүлсэн нь бидний амжилт хэмээн үзэж болно гэж онцлов.

**Сорилтууд:**

**Эдийн засгийн бодлого, ажлын байр, ядуурал:**

- Хэнтий аймагт ядуурал, ажилгүйдлийн түвшин өндөр байгааг шийдвэрлэх хэрэгтэй.
- Монголын эдийн засагт эрдэс баялгийн салбараас хамааралтай тул эдийн засгийг төрөлжүүлэх хэрэгтэй.
- Ядуурлыг тооцох аргачлалыг өөрчлөн, Монголд илүү тохиромжтой аргуудыг хэрэглэх хэрэгтэй, жишээ нь олон талт ядуурлыг хэмжих аргачлал. Орлогын тэгш бус байдлыг зөв зохистой үнэлэх хэрэгтэй.

**Хувийн хэвшлийн хөгжил:**

- Орон нутгаас баримталж буй зээлийн бодлого нь хувийн хэвшлийг дэмждэггүй, зах зээлийн хэв шинж, эрэлттэй нийцдэггүй.
- Жижиг дунд үйлдвэрлэлийн дэмжих бодлого, тэр дундаа өрхийн аж ахуйг дэмжих бодлогыг сайтар боловсруулах шаардлагатай. Засгийн газраас орон нутгийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих бодлогын арга хэмжээ авах хэрэгтэй. Засгийн газраас мөн уул уурхайд түшиглэсэн аж үйлдвэрүүдийг хөгжүүлэхэд анхаарах нь зүйтэй.
- Орон нутагт бизнес эрхлэх, худалдан авах ажиллагаанд оролцох хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх хэрэгтэй. Мөн орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг худалдан авах ажиллагаанд оролцуулах боломжийг илүү их олгох хэрэгтэй.
- Улсын Их Хурлаас инновацийн тухай хуулийг нэн даруй батлаж, хөдөө орон нутгийн энтэрпрэнэрүүд болон бизнесийн хөгжлийг дэмжих хэрэгтэй.
- Зээлийг илүү хүртээмжтэй болгон, дамжуулан зээлдэх дүрэм журам, хугацаа болон хүүг бууруулахад анхаарах нь зүйтэй.
- Хөрөнгө оруулалтын үр ашгийг нэн яаралтай үнэлэх хэрэгтэй байна. Жишээ нь, шинэ зам бариснаас хуучин замны засварт хөрөнгө оруулалт хийх нь нэн тэргүүний ач холбогдолтой юм.
- Мега компаниудын үйл ажиллагааг зарим талаар хязгаарлах нь зүйтэй. Жишээ нь тэдний үйл ажиллагааг тодорхой хэдэн салбар, зах зээлээр хязгаарлах зэрэг. Ингэснээр дундаж давхаргыг дэмжин, бизнесийн өрсөлдөөнийг бие болгох юм.
- Хувийн компаниуд зах зээл, бүтээгдэхүүний судалгаа хийх чадвар болон экспортын чадамжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.
- Хэнтэй аймагт аж үйлдвэрийн салбарын өрсөлдөх чадвар, дэд бүтэц болон ложистикийн асуудлууд нь хувийн хэвшлийн хөгжилд тушаа болж байна.

### **Хөдөө аж ахуй:**

- Хөдөө аж ахуйн түүхий эдэд түшиглэсэн хөнгөн үйлдвэрлэлийн хөгжил нь хөдөө орон нутгийн хөгжлийн тэргүүлэх зорилт юм.
- Тариаланч фермэрүүд, жижиг бизнесүүдийг дэмжихийн тулд ногооны зоорь барих нь Хэнтий аймагт ЖДҮ-дийг дэмжихэд нэн чухал үүрэгтэй.
- Бэлчээрийн зохистой бодлого мөн хөдөө аж ахуйн салбар, орон нутгийг хөгжүүлэхэд чухал юм.
- Хэнтий аймагт гурилын үйлдвэр барих боломжийг судлах хэрэгтэй.
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг дэмжих цогц арга хэмжээ авах хэрэгтэй байна. Үүнд экспортын зах зээлийг тэлэх, Монгол мах болон бусад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний органик шинж чанарыг сурталчлах, импортын бүтээгдэхүүний тарифын бодлогоор зохицуулах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг тооцоолох, зам тээврийн асуудлуудыг шийдвэрлэх г.м. арга хэмжээ орно.
- Малын эрүүл мэнд нь нэн тулгамдсан асуудал болоод байгаа бөгөөд мал сүргийн дэлгэрэнгүй мэдээлэл, хянах системийг бий болгох хэрэгтэй. Мал эмнэлгийн чадавх, технологийг сайжруулах шаардлагатай.
- Малын хөлийн болон бэлчээр ашигласны татварыг малчдаас авдаг болохыг бодолцон үзэх хэрэгтэй.
- Арьс шир боловсруулах үйлдвэр зэрэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээх үйл ажиллагааг илүү боловсронгуй болгон хөгжүүлэх хэрэгтэй.
- Байгалийн гамшигт илүү тэсвэртэй болох, шинэ технологи нэвтрүүлэх нь зүйтэй.

### **Засаглал:**

- Хэнтий аймаг зүүн бүсийн тулгуур төв болохын тулд бүс нутгийн хөгжлийн бодлого зайлшгүй хэрэгтэй.
- Сүүлийн үеийн нийгэм эдийн засгийн бодлого хэтэрхий богино хугацааны зорилтот түшиглэж ирсэн. Монгол улсын цаашдын хөгжилд урт хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлт хамгийн чухал үүрэгтэй.
- Монгол дахь засаглалын асуудлыг шийдвэрлэхийн тулд төрийн албаны шинэчлэлийг яаралтай хийж, төрийн албаны чанарыг сайжруулж, хүнд суртлыг бууруулах, Засгийн газрын агентлаг, харьяа байгууллагуудын чиг үүргийг нягтлан харах шаардлагатай. Мөн төрийн албаны залгамж чанар маш суларсан бөгөөд төрийн албаны ажлыг илүү тогтвортой болгон, сонгуулийн мөчлөгөөс хараат халаа сэлгээг зогсоох хэрэгтэй байна. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд төрийн албаны хараат бус зөвлөлийг байгуулах хэрэгтэй.
- Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа нь хувийн хэвшлийн хөгжлийн хурдтай хөл нийлүүлэн алхаж чаддаггүй.
- Засгийн газрын ил тод байдал ерөнхийдөө сайжрах хэрэгтэй. Мэдээ мэдээллийн чанар муу байгаа тул хөдөө орон нутагт үнэлгээний байгууллагууд зэрэг мэргэжлийн мэдээллийн байгууллагуудыг бий болгох хэрэгтэй юм. Олон нийтэд үнэн зөв мэдээлэл хүргэх, иргэдийн боловсролыг сайжруулахын тулд мэдээллийн үнэн зөв байдал, чанарыг нягтлан хянадаг бүтэц бий болгох нь зүйтэй. Бодлого боловсруулагч нар болон хувийн хэвшил, иргэдийн хооронд байгаа мэдлэг мэдээллийн зөрүүг багасгах, арилгах хэрэгтэй.
- Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулан, цалин, тэтгэвэр, нийгмийн халамжийн бодлогыг эргэн харах шаардлагатай болсон. Мөн хүмүүс нийгмийн халамжид хэтэрхий их найдаж байгаа сэтгэлгээг өөрчлөх хэрэгтэй.
- Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийг сонгох арга, шалгууруудыг эргэн харах хэрэгтэй.

- Орон нутагт нотолгоонд суурилсан шийдвэр гаргах үйл явцыг хэвшүүлэх, нутагшуулах шаардлагатай байна. Үүний тулд судалгааны байгууллагуудыг дэмжин, эрдэмтэн судлаач нар болон бодлого боловсруулдаг байгууллагуудыг хооронд нь холбох хэрэгтэй. Мөн судалгаа шинжилгээний чанарыг сайжруулан, төрийн албаны шат бүрт хариуцлагын механизмыг сайжруулах шаардлагатай байна.

**Боловсрол:**

- Төрөөс олгож буй боловсролын чанар муу байгаа бөгөөд маш их хөрөнгө мөнгө гадагш сургуульд сурахад шаардагдаж байна. Эдийн засгийн мэдлэгийг сайжруулан, Монгол улсын тэргүүлэх ач холбогдолтой салбарт ажилладаг эрдэмтэн судлаач нарыг буцаад авчрахад анхаарах хэрэгтэй. Байгалийн баялаг ихтэй бусад улс орнуудтай харьцуулахад Монгол улс боловсролын салбартаа төдийлөн их хөрөнгө зарцуулахгүй байна.
- Дээд боловсролыг цогцоор нь шинэчлэх шаардлагатай болжээ. Дээд боловсролд хэтэрхий их ач холбогдол өгч, хувийн их дээд сургуулиудын тоо хэт олширсон.
- Их дээд сургуулиуд хотод төвлөрсөн нь нийслэл хот руу шилжих хөдөлгөөнийг улам даамжруулж байна. Томоохон их дээд сургуулиудыг хотоос гаргах хэрэгтэй.
- Мөн нийгмийн эрүүл мэндийн тухай олон нийтийн мэдлэгийг бэхжүүлж, хорт хавдар болон Монголд элбэг тохиолддог бусад өвчний талаар мэдээлэл олгоосой.

**Бусад:**

- Хот төлөвлөлтийн стратеги төлөвлөгөөг дахин харах хэрэгтэй.
- Уул уурхай болон хөдөө аж ахуйн салбаруудад байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон засаглалын үнэлгээг хийх хэрэгтэй.

<p><b>ДБГ-ийн стратеги ба түншлэлийн талаарх санал</b></p>	<p><b>Стратеги:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• ДБГ нь бодлогын дүн шинжилгээ болон нотолгоонд суурилсан бодлого боловсруулах явцыг дэмжих замаар засаглалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой. Бодлогын зөвлөмж нь улс орны онцлог, нөхцөл байдалд тохирсон байх хэрэгтэй. Дэлхийн Банк нь мөн төрийн албан хаагчид, төрийн албаны тогтолцоог илүү хариуцлагатай болгоход туслах хэрэгтэй. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан бодлогын залгамж чанарыг хадгалахад анхаарах нь зүйтэй.</li> <li>• ДБГ нь мөн нийгэмд оролцож буй бүхий л талуудын оролцоог хангахын тулд салбарын зөвлөлдөх механизм, аргачлалыг нэвтрүүлэх хэрэгтэй. Эдгээр зөвлөлдөх арга замыг ашиглан салбарын стратегиудыг шинэчлэх хэрэгтэй.</li> <li>• Эдийн засагт буй тодорхой бус байдлыг харгалзан Дэлхийн Банкны зүгээс хувийн хэвшлийн шийдвэр гаргах, төлөвлөх чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь зүйтэй.</li> <li>• Хөрөнгийн зах зээлийг бэхжүүлж, санхүүгийн мэдээллийг илүү ил тод болгоход анхаарах.</li> <li>• Уул уурхайн салбарт гадны хөрөнгө оруулагчид нэгэнтээ орж ирсэн тул Дэлхийн Банкны зүгээс уг салбарт оролцох оролцоо хязгаарлагдмал байх нь зүйтэй.</li> <li>• Ирэх 10 жилийн хугацаанд Дэлхийн Банкны зүгээс хүний хөгжил, тэр дундаа боловсрол, эрүүл мэндийн чиглэлд дэмжлэг үзүүлэн ажиллах хэрэгтэй.</li> <li>• Мөн Банкны зүгээс мега төслүүдийг бэлтгэхэд хүний нөөцийг бий болгох, техникийн туслалцаа үзүүлэх болон зөвлөмж олгох зэргээр оролцох хэрэгтэй.</li> <li>• Ажилгүй эмэгтэйчүүдэд ажлын байр бий болгохын тулд хөдөө орон нутагт илүүтэйгээр чиглэсэн төслүүдийг хэрэгжүүлэх хэрэгтэй.</li> <li>• Банкны зүгээс мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих төслүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй.</li> <li>• Банкны батлан даалтын сангийн үйл ажиллагааг илүү бэхжүүлэхэд Дэлхийн Банкнаас дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.</li> <li>• ДБ-ны гэр цэцэрлэгийн төсөл маш амжилттай хэрэгжсэн бөгөөд үүнийг үргэлжлүүлэх хэрэгтэй.</li> </ul> <p><b>Хэрэгжилт, аргачлал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Төслүүдийн чанарын үзүүлэлтүүдийг сайжруулж, төслүүд амжилттай сайн хэрэгжихэд илүү их анхаарал хандуулах хэрэгтэй.</li> </ul>
--	--

Уулзалтын үеэр оролцогчдоос авсан товч судалгааны хариу:

1. Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг бууруулж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултаудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Боловсрол	8	38%
— Эрүүл мэнд	7	33%
— Төрийн удирдлага/шинэтгэл	6	29%
— Хөдөөгийн хөгжил	5	24%
— Хүнсний аюулгүй байдал	5	24%

— Худалдаа, экспорт	5	24%
— Авлигатай тэмцэх	4	19%
— Хувийн хэвшлийг хөгжүүлэх	4	19%
— Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	4	19%
— Байгалийн нөөцийн удирдлага	2	10%
— Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	2	10%
— Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	2	10%
— Нийгмийн хамгаалал	2	10%
— Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах	2	10%
— Эдийн засгийн өсөлт	1	5%
— Эрх тэгш боломжоор хангах	1	5%
— Санхүүгийн зах зээл	1	5%
— Гадаадын хөрөнгө оруулалт	1	5%
— Зам, тээвэр	1	5%
— Бусад	1 (аж үйлдвэрийн хөгжил)	5%
— Гамшгийн эрсдэлийн удирдлага	0	0%
— Хотын хөгжил	0	0%
— Эрчим хүч	0	0%
— Ус, ариун цэврийн байгууламж	0	0%

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж Та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

Хүний хөгжлийг дэмжих	11	52%
Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	9	43%
Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	9	43%
Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих	9	43%
Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	8	38%
Бүгд чухал	1	5%